



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Биеийн тамир, спортын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДУА-2023/17/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Дундговь аймаг

2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох

Утас: 70592439

Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Наранцацрал

Утас: 70592225

Цахим хаяг: Narantsatsralkh@audit.gov.mn

Аудитор: Г.Отгонбаатар

Утас: 70110090

Цахим хаяг: Otgonbaatar.g@azure.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: Dundgovi@audit.gov.mn

ДУНДГОВЬ АЙМГИЙН
БИЕИЙН ТАМИР СПОРТЫН
ГАЗРЫН ДАРГА
А.ОТГОНБААТАР ТАНАА

2023.02.27 № 110.
танай _____ -ны № _____ -г

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Биеийн тамир, спортын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Биеийн тамир, спортын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тайлант онд нийт 555,382.8 мянган төгрөгийн хөрөнгийг хүлээн авч бүртгэсэн байна. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

0012020211

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Р.МӨНХТОГТОХ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|--------------|-----------------------------------------------------------------------|-------------------------|-------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I) | 56,678,504.14 | 68,960,001.14 |
| 33 | АВЛАГА | - | 10,500,000.00 |
| 33500 | Бусад авлага | - | 10,500,000.00 |
| 33510 | Байгууллагаас авах авлага | - | 10,500,000.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 56,678,504.14 | 58,460,001.14 |
| 35100 | Түүхий эд материал | 40,955,264.14 | 44,301,981.14 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 40,955,264.14 | 44,301,981.14 |
| 35400 | Хангамжийн материал | 15,723,240.00 | 14,158,020.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,499,590.00 | 1,387,600.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 13,743,650.00 | 12,520,420.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 480,000.00 | 250,000.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II) | 3,373,522,574.14 | 3,826,253,005.11 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 3,373,522,574.14 | 3,826,253,005.11 |
| 39200 | Биет хөрөнгө | 2,517,994,574.10 | 2,790,813,005.03 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,882,905,960.67 | 3,218,288,780.67 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл - Барилга | (459,289,055.62) | (545,670,860.54) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 47,100,000.00 | 47,100,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл - Тээврийн хэрэгсэл | (17,400,000.06) | (27,500,000.10) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 52,793,679.90 | 84,793,679.90 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж | (17,175,867.82) | (28,794,436.39) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 70,925,049.90 | 96,925,049.34 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл - Тавилга | (41,865,192.87) | (54,329,207.85) |
| 39300 | Биет бус хөрөнгө | 855,528,000.04 | 1,035,440,000.08 |
| 39301 | Программ хангамж | 880,000.00 | 880,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл - Программ хангамж | (527,999.96) | (615,999.92) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 855,176,000.00 | 1,035,176,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II) | 3,430,201,078.28 | 3,895,213,006.25 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V) | 3,430,201,078.28 | 3,895,213,006.25 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 3,430,201,078.28 | 3,895,213,006.25 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,020,878,143.04 | 1,020,878,143.04 |
| 511001 | Засгийн газрын оруулсан капитал засгийн газрын сан | 1,020,878,143.04 | 1,020,878,143.04 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 2,056,480,512.40 | 2,521,492,440.37 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 2,176,160,427.21 | 2,056,480,512.40 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | (119,679,914.81) | 465,011,927.97 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 352,842,422.84 | 352,842,422.84 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V) | 3,430,201,078.28 | 3,895,213,006.25 |
| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I) | 56,678,504.14 | 68,960,001.14 |
| 33 | АВЛАГА | - | 10,500,000.00 |
| 33500 | Бусад авлага | - | 10,500,000.00 |
| 33510 | Байгууллагаас авах авлага | - | 10,500,000.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 56,678,504.14 | 58,460,001.14 |
| 35100 | Түүхий эд материал | 40,955,264.14 | 44,301,981.14 |

| | | | |
|-----------|-----------------------------------------------------------------------|-------------------------|-------------------------|
| 35110 | Тусгай зориулалттай материал | 40,955,264.14 | 44,301,981.14 |
| 35400 | Хангамжийн материал | 15,723,240.00 | 14,158,020.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,499,590.00 | 1,387,600.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 13,743,650.00 | 12,520,420.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 480,000.00 | 250,000.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II) | 3,373,522,574.14 | 3,826,253,005.11 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 3,373,522,574.14 | 3,826,253,005.11 |
| 39200 | Биет хөрөнгө | 2,517,994,574.10 | 2,790,813,005.03 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,882,905,960.67 | 3,218,288,780.67 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл - Барилга | (459,289,055.62) | (545,670,860.54) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 47,100,000.00 | 47,100,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл - Тээврийн хэрэгсэл | (17,400,000.06) | (27,500,000.10) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 52,793,679.90 | 84,793,679.90 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж | (17,175,867.82) | (28,794,436.39) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 70,925,049.90 | 96,925,049.34 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл - Тавилга | (41,865,192.87) | (54,329,207.85) |
| 39300 | Биет бус хөрөнгө | 855,528,000.04 | 1,035,440,000.08 |
| 39301 | Программ хангамж | 880,000.00 | 880,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл - Программ хангамж | (527,999.96) | (615,999.92) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 855,176,000.00 | 1,035,176,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II) | 3,430,201,078.28 | 3,895,213,006.25 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V) | 3,430,201,078.28 | 3,895,213,006.25 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 3,430,201,078.28 | 3,895,213,006.25 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,020,878,143.04 | 1,020,878,143.04 |
| 511001 | Засгийн газрын оруулсан капитал засгийн газрын сан | 1,020,878,143.04 | 1,020,878,143.04 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 2,056,480,512.40 | 2,521,492,440.37 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 2,176,160,427.21 | 2,056,480,512.40 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | (119,679,914.81) | 465,011,927.97 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 352,842,422.84 | 352,842,422.84 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V) | 3,430,201,078.28 | 3,895,213,006.25 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|-----------|------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------|-------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 469,490,160.00 | 1,159,840,524.44 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 4,160,060.00 | 566,636,124.44 |
| 1200 | Нийтлэг татварын бус орлого | 4,160,060.00 | 566,636,124.44 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 4,160,060.00 | 555,382,819.44 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Материал | - | 11,253,305.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 465,330,100.00 | 593,204,400.00 |
| 1310 | Улсын төсвөөс | 204,807,100.00 | 310,487,800.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 204,807,100.00 | 310,487,800.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 28,007,000.00 | 64,799,400.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х | 9,674,000.00 | 48,226,300.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 18,333,000.00 | 16,573,100.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 232,516,000.00 | 217,917,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 232,516,000.00 | 217,917,200.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II) | 587,830,699.58 | 693,575,291.47 |

| | | | |
|-----------|----------------------------------------------------------------------|-------------------------|-----------------------|
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 587,830,699.58 | 693,575,291.47 |
| 210 | БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 583,811,930.83 | 682,046,704.64 |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 152,167,587.71 | 189,551,812.18 |
| 210101 | Үндсэн цалин | 113,595,373.71 | 125,193,308.18 |
| 210102 | Нэмэгдэл | 38,572,214.00 | 35,895,950.00 |
| 210103 | Унаа хоолны Хөнгөлөлт | - | 18,081,000.00 |
| 210104 | Урамшуулал | - | 10,381,554.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 19,331,223.83 | 23,399,981.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 13,340,319.27 | 15,982,352.40 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,486,758.87 | 1,880,276.21 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,604,529.54 | 1,494,140.99 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 263,602.27 | 367,564.55 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,636,013.88 | 3,675,646.85 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 187,892,652.71 | 193,157,084.09 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,070,036.01 | 3,726,507.59 |
| 210302 | Түлш, халаалт | 184,830,748.70 | 183,314,174.50 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,991,868.00 | 6,116,402.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 18,287,680.78 | 14,782,670.30 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,309,925.00 | 1,661,840.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,360,000.00 | 3,079,155.30 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 893,120.00 | 908,600.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 617,648.00 | 27,600.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,090,530.00 | 6,537,925.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 11,016,457.78 | 2,567,550.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 49,537,940.00 | 9,965,280.00 |
| 210604 | Урсгал засвар | 49,537,940.00 | 9,965,280.00 |
| 2107 | Томиллолт, зочны зардал | 1,465,500.00 | 676,000.00 |
| 210702 | Дотоод албан томиллолт | 1,465,500.00 | 676,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 7,610,609.00 | 3,744,865.60 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 7,610,609.00 | 1,430,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | - | 498,500.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | - | 114,865.60 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | - | 33,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 360,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | - | 1,308,500.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 147,518,736.80 | 246,769,011.47 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 30,789,344.00 | 124,216,623.00 |
| 210902 | Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх | - | 1,900,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол | 116,729,392.80 | 120,652,388.47 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 4,018,768.75 | 11,528,586.83 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 1,416,830.00 | 460,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,416,830.00 | 460,000.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 2,593,891.46 | 1,756,347.91 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,593,891.46 | 1,756,347.91 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 8,047.29 | 9,312,238.92 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 8,047.29 | 9,312,238.92 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II) | (118,340,539.58) | 466,265,232.97 |
| 5 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V) | 1,339,375.23 | 1,253,305.00 |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ | 1,339,375.23 | 1,253,305.00 |
| 225001 | Үүндсэн хөрөнгө худалдсаны гарз | 1,339,375.23 | - |
| 225011 | Үнэ төлбөргүй гарсан зардал зардал - бараа материал | - | 1,253,305.00 |
| 6 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V) | (119,679,914.81) | 465,011,927.97 |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|-----------|------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------|-----------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 465,330,100.00 | 593,204,400.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 465,330,100.00 | 593,204,400.00 |
| 1310 | Улсын төсвөөс | 204,807,100.00 | 310,487,800.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 204,807,100.00 | 310,487,800.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 28,007,000.00 | 64,799,400.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х | 9,674,000.00 | 48,226,300.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 18,333,000.00 | 16,573,100.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 232,516,000.00 | 217,917,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 232,516,000.00 | 217,917,200.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II) | 445,870,100.00 | 575,204,400.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 445,870,100.00 | 575,204,400.00 |
| 210 | БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 442,368,161.25 | 563,675,813.17 |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 152,167,587.71 | 189,551,812.18 |
| 210101 | Үндсэн цалин | 113,595,373.71 | 125,193,308.18 |
| 210102 | Нэмэгдэл | 38,572,214.00 | 35,895,950.00 |
| 210103 | Унаа хоолны Хөнгөлөлт | - | 18,081,000.00 |
| 210104 | Урамшуулал | - | 10,381,554.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 19,331,223.83 | 23,399,981.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 13,340,319.27 | 15,982,352.40 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,486,758.87 | 1,880,276.21 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,604,529.54 | 1,494,140.99 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 263,602.27 | 367,564.55 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,636,013.88 | 3,675,646.85 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 190,892,652.71 | 193,157,084.09 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,570,036.01 | 3,726,507.59 |
| 210302 | Түлш, халаалт | 184,830,748.70 | 183,314,174.50 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,491,868.00 | 6,116,402.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 5,885,858.00 | 8,474,745.30 |
| 210401 | Бичиг хэрэг | 976,840.00 | 1,367,350.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,160,000.00 | 2,849,155.30 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 893,120.00 | 908,600.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 617,648.00 | 27,600.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,238,250.00 | 3,322,040.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 42,146,300.00 | 11,291,885.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 200,000.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 41,946,300.00 | 11,291,885.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,465,500.00 | 676,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,465,500.00 | 676,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 8,017,709.00 | 3,884,865.60 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 8,017,709.00 | 1,430,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | - | 498,500.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | - | 114,865.60 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | - | 33,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 500,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | - | 1,308,500.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 22,461,330.00 | 133,239,440.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 22,461,330.00 | 131,339,440.00 |
| 210902 | Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх | - | 1,900,000.00 |

| | | | |
|-----------|----------------------------------------------------------------------|------------------------|------------------------|
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 3,501,938.75 | 11,528,586.83 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 900,000.00 | 460,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 900,000.00 | 460,000.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 2,593,891.46 | 1,756,347.91 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,593,891.46 | 1,756,347.91 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 8,047.29 | 9,312,238.92 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 8,047.29 | 9,312,238.92 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II) | 19,460,000.00 | 18,000,000.00 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 19,460,000.00 | 18,000,000.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 19,460,000.00 | 18,000,000.00 |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ | 19,460,000.00 | 18,000,000.00 |
| 2251 | Үндсэн хөрөнгө олж бэлтгэхэд төлсөн | 19,460,000.00 | - |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 19,460,000.00 | 18,000,000.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=IV-V) | (19,460,000.00) | (18,000,000.00) |
| 7 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VII) | - | - |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII) | - | - |
| 14 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - |
| 15 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Засгийн хөрөнгө оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|----------------------------------------------|----------------------------------|-----------------------|-------------------------|----------------------------------------|
| 2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 1,020,878,143.04 | 352,842,422.84 | 2,056,480,512.40 | 3,430,201,078.28 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,020,878,143.04 | 352,842,422.84 | 2,056,480,512.40 | 3,430,201,078.28 |
| Тайлант үеийн үр дүн | | | 465,011,927.97 | 465,011,927.97 |
| 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,020,878,143.04 | 352,842,422.84 | 2,521,492,440.37 | 3,895,213,006.25 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | |
|------------------------------------------|-----------------------|-----------------------|---------------------|---------------|
| | | | Дүнгээр | % |
| Биеийн тамир спорт | 310,487,800.00 | 310,487,800.00 | - | 100.00 |
| Үндсэн үйл ажиллагааны зардал | 221,226,100.00 | 221,226,100.00 | - | 100.00 |
| Татварын бус орлого | 221,226,100.00 | 221,226,100.00 | - | 100.00 |
| Тусламжийн орлого | 221,226,100.00 | 221,226,100.00 | - | 100.00 |
| Төсвөөс санхүүжих | 221,226,100.00 | 221,226,100.00 | - | 100.00 |
| НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 221,226,100.00 | 221,226,100.00 | - | 100.00 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 221,226,100.00 | 214,119,416.08 | 7,106,683.92 | 96.79 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 221,226,100.00 | 214,119,416.08 | 7,106,683.92 | 96.79 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 179,567,600.00 | 176,452,001.18 | 3,115,598.82 | 98.26 |
| Үндсэн цалин | 115,785,600.00 | 115,465,329.18 | 320,270.82 | 99.72 |
| Нэмэгдэл | 33,147,800.00 | 33,474,118.00 | (326,318.00) | 100.98 |
| Унаа хоолны хөнгөлөлт | 18,900,000.00 | 17,131,000.00 | 1,769,000.00 | 90.64 |
| Урамшуулал | 11,734,200.00 | 10,381,554.00 | 1,352,646.00 | 88.47 |

| | | | | |
|----------------------------------------------------------------------|----------------------|----------------------|-----------------------|---------------|
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 22,445,900.00 | 21,789,304.00 | 656,596.00 | 97.07 |
| Тэтгэврийн даатгал | 15,263,200.00 | 14,868,866.93 | 394,333.07 | 97.42 |
| Тэтгэмжийн даатгал | 1,795,700.00 | 1,749,278.10 | 46,421.90 | 97.41 |
| ҮОМШӨ-ний даатгал | 1,436,500.00 | 1,389,342.51 | 47,157.49 | 96.72 |
| Ажилгүйдлийн даатгал | 359,100.00 | 343,801.37 | 15,298.63 | 95.74 |
| Эрүүл мэндийн даатгал | 3,591,400.00 | 3,438,015.09 | 153,384.91 | 95.73 |
| Хангамж, бараа материалын зардал | 9,594,100.00 | 8,474,745.30 | 1,119,354.70 | 88.33 |
| Бичиг хэрэг | 1,372,800.00 | 1,367,350.00 | 5,450.00 | 99.60 |
| Тээвэр, шатахуун | 2,860,000.00 | 2,849,155.30 | 10,844.70 | 99.62 |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,464,300.00 | 908,600.00 | 555,700.00 | 62.05 |
| Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 572,000.00 | 27,600.00 | 544,400.00 | 4.83 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,325,000.00 | 3,322,040.00 | 2,960.00 | 99.91 |
| Томилолт, зочны зардал | 1,916,000.00 | 676,000.00 | 1,240,000.00 | 35.28 |
| Дотоод албан томилолт | 1,916,000.00 | 676,000.00 | 1,240,000.00 | 35.28 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж | 4,842,500.00 | 3,884,865.60 | 957,634.40 | 80.22 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,430,000.00 | 1,430,000.00 | - | 100.00 |
| Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 700,000.00 | - | 700,000.00 | - |
| Даатгалын үйлчилгээ | 500,000.00 | 498,500.00 | 1,500.00 | 99.70 |
| Тээврийн хэрэгслийн татвар | 338,000.00 | 114,865.60 | 223,134.40 | 33.98 |
| Тээврийн хэрэгслийн оношилгоо | 66,000.00 | 33,000.00 | 33,000.00 | 50.00 |
| Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 500,000.00 | 500,000.00 | - | 100.00 |
| Газрын төлбөр | 1,308,500.00 | 1,308,500.00 | - | 100.00 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 2,860,000.00 | 2,842,500.00 | 17,500.00 | 99.39 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 958,000.00 | 942,500.00 | 15,500.00 | 98.38 |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,902,000.00 | 1,900,000.00 | 2,000.00 | 99.89 |
| 26 | - | 7,106,683.92 | (7,106,683.92) | - |
| Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 7,106,683.92 | (7,106,683.92) | - |
| Биеийн тамирын уралдаан, тэмцээн | 65,341,500.00 | 65,341,500.00 | - | 100.00 |
| Татварын бус орлого | 65,341,500.00 | 65,341,500.00 | - | 100.00 |
| Тусламжийн орлого | 65,341,500.00 | 65,341,500.00 | - | 100.00 |
| Төсвөөс санхүүжих | 65,341,500.00 | 65,341,500.00 | - | 100.00 |
| НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 65,341,500.00 | 65,341,500.00 | - | 100.00 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 65,341,500.00 | 65,229,840.00 | 111,660.00 | 99.83 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 65,341,500.00 | 65,229,840.00 | 111,660.00 | 99.83 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 65,341,500.00 | 65,229,840.00 | 111,660.00 | 99.83 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 65,341,500.00 | 65,229,840.00 | 111,660.00 | 99.83 |
| 26 | - | 111,660.00 | (111,660.00) | - |
| Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 111,660.00 | (111,660.00) | - |
| Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг | 1,465,000.00 | 1,465,000.00 | - | 100.00 |
| Татварын бус орлого | 1,465,000.00 | 1,465,000.00 | - | 100.00 |
| Тусламжийн орлого | 1,465,000.00 | 1,465,000.00 | - | 100.00 |
| Төсвөөс санхүүжих | 1,465,000.00 | 1,465,000.00 | - | 100.00 |
| НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,465,000.00 | 1,465,000.00 | - | 100.00 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 1,465,000.00 | 460,000.00 | 1,005,000.00 | 31.40 |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1,465,000.00 | 460,000.00 | 1,005,000.00 | 31.40 |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,465,000.00 | 460,000.00 | 1,005,000.00 | 31.40 |
| 26 | - | 1,005,000.00 | (1,005,000.00) | - |
| Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 1,005,000.00 | (1,005,000.00) | - |
| Нийтийн биеийн тамир | 22,455,200.00 | 22,455,200.00 | - | 100.00 |
| Татварын бус орлого | 22,455,200.00 | 22,455,200.00 | - | 100.00 |

| | | | | |
|------------------------------------------|----------------------|----------------------|--------------------|---------------|
| Тусламжийн орлого | 22,455,200.00 | 22,455,200.00 | - | 100.00 |
| Төсвөөс санхүүжих | 22,455,200.00 | 22,455,200.00 | - | 100.00 |
| НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 22,455,200.00 | 22,455,200.00 | - | 100.00 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 22,455,200.00 | 22,370,800.00 | 84,400.00 | 99.62 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 22,455,200.00 | 22,370,800.00 | 84,400.00 | 99.62 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 22,455,200.00 | 22,370,800.00 | 84,400.00 | 99.62 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 22,455,200.00 | 22,370,800.00 | 84,400.00 | 99.62 |
| 26 | - | 84,400.00 | (84,400.00) | - |
| Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 84,400.00 | (84,400.00) | - |

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|-------------|------------------------------------------------------------------------------------------------------|----------------------|
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (I) | 64,799,400.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 64,799,400.00 |
| 210 | БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 63,794,905.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 20,998,605.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 18,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,998,605.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 42,796,300.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 42,796,300.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1,004,495.00 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 1,004,495.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,004,495.00 |
| II | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР (II) | 64,799,400.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 64,799,400.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 64,799,400.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х | 48,226,300.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 16,573,100.00 |

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дундговь аймгийн Биеийн тамир спортын газар нь эрхэм зорилгоо “Аймаг, орон нутагт биеийн тамир, спорт хөгжих орчин нөхцөлийг бүрдүүлэн эрүүл чийрэг бие бялдартай, иргэд хамт олныг төлөвшүүлэх, биеийн тамир спортыг нийтийн хүртээл болгон өндөр зэрэг, цолтой тамирчдыг бэлтгэн гаргах явдал юм” гэж тодорхойлжээ. Дундговь аймгийн хэмжээнд 15 сумын ард иргэдэд биеийн тамир уралдаан тэмцээний ажил үйлчилгээг хүргэн ажиллаж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, зэрэг нь байгууллагын үйл ажиллагаа явуулах эрх зүйн орчин юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль;

- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Биеийн тамир, спортын тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль;
- Засгийн газрын 2021 оны 388 дугаар “Монгол улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоол;
- Засгийн газрын 2022 оны 107 дугаар “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” тогтоол;
- Засгийн газрын 2022 оны 192 дугаар “Тогтоол, тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” тогтоол;
- Засгийн газрын 2022 оны 488 тоот “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоол;
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/191 дүгээр тушаал “Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам”;
- Сангийн сайдын 2022 оны 120 дугаар тушаал “Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай”;

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус онд байгууллагын үйл ажиллагаанд санхүүгийн хяналт, дотоод аудитын шалгалтууд хийгдээгүй.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дундговь аймгийн Биеийн тамир, спортын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дундговь аймгийн Биеийн тамир, спортын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 465,012.0 мянган төгрөгөөр буюу 13 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|----------------------------------------------|--------------------|--------------------|------------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Бараа материал | 56,678.5 | 68,960.0 | 12,281.5 |
| Үндсэн хөрөнгө | 3,373,522.5 | 3,826,253.0 | 452,730.5 |
| Нийт хөрөнгө | 3,430,201.0 | 3,895,213.0 | 465,012.0 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 3,430,201.0 | 3,895,213.0 | 465,011.9 |
| Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн | 3,430,201.0 | 3,895,213.0 | 465,011.9 |

Дээрх хүснэгтээс харахад, үндсэн хөрөнгийн дансанд өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл нь 3,826,253.0 мянга болж 452,730.4 мянган төгрөгөөр өссөн нь нийт 555,382.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг хандиваар хүлээн авсан үүнд Биеийн тамир спортын газрын барилгыг дээврийн засварын ажил 135,382.8 мянга, Аймгийн төвийн авто замын дагуух гэр хорооллын гудамжны тохижилтын ажил 200,000.0 мянга, Спорт цогцолборын газар 180,000.0 мянга, жүдогийн олон улсын стандартад нийцсэн дэвжээ 20,000.0 мянга, Дундговь буудлагын спортын холбооны албан хэрэгцээнд буу электрон бай 20,000.0 мянган төгрөгөөр тус тус тусгаж тайлант хугацааны элэгдлийн зардлыг 120,652.4 мянган төгрөгөөр тооцож бүртгэснээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 352,484.2 мянга, орон нутгийн төсвөөс 455,476.0 мянган төгрөг нийт 807,960.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 267,421.8 мянган төгрөгөөр бууруулж, улсын төсвийг 322,621.2 мянга, орон нутгийн төсвийг 217,917.2 мянган төгрөгөөр нийт 540,538.4 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь төсвийн төсөлд байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг орон нутгийн төсөвт хийсвэрээр тавьж түүнийг бууруулснаас шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 310,487.8 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 217,917.2 мянган төгрөгийг баталснаас 100% төсвийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 582,135.9 мянган төгрөг буюу 98.3 хувь зарцуулж, 11,068.5 мянган төгрөгийн төвлөрүүлэх шилжүүлэг хийсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|-----|----------------------------------------------------------|------------|-----------|-----------|---------|
| 1 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 179,567.6 | 176,452.0 | 3,115.6 | 98% |
| 2 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 22,445.9 | 21,789.3 | (656.6) | 97% |
| 3 | Хангамж, бараа материалын зардал | 9,594.1 | 8,474.7 | (1,119.4) | 88% |
| 4 | Томилолт, зочны зардал | 1,916.0 | 676.0 | (1,240.0) | 35% |
| 5 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 4,842.5 | 3,884.8 | (957.6) | 80% |
| | Эд хогшил, урсгал засварын зардал | 8,300.0 | 8,293.2 | 6.7 | 99% |
| 6 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,860.0 | 2,842.5 | (17.5) | 99% |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан 48,226.3 мянган төгрөг, өөрийн үйл ажиллагааны орлогоос бүрдүүлсэн 16,573.1 мянган төгрөг, нийт 64,799.4 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэн байна. Үүнээс нэмэлт санхүүжилтийн төсвийг засварын зардал, багаж техник хэрэгсэл 18,000.0 мянга, урсгал засвар 2,998.6 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 42,796.3 мянган төгрөг тус тус зарцуулж 1,004.5 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дундговь аймгийн Биеийн тамир, спортын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Азуре хүлүг аудит ХХК-ийн аудитор Г.Отгонбаатар, аудиторын туслах Л.Энх-Уянга нар гүйцэтгэж, анхан шатны чанарын хяналтын менежер С.Оюунцэцэг, хоёр дахь шатны хяналтыг гүйцэтгэх захирал Г.Мөнхбаяр нар гүйцэтгэж, чанарын хяналтыг Дундговь аймаг дахь Төрийн аудитын менежер Х.Наранцацрал, дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох нар тус тус хэрэгжүүлсэн.

Дундговь аймгийн Биеийн тамир, спортын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 104 тоот бичгийг ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 587,830.7 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 5,878.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллагад 33 арга хэмжээг түүвэрлэн шалгахаар төлөвлөн хэрэгжүүллээ. Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотой алдаа, зөрчил илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим сайтад 9 мэдээлэл хугацаа хоцроож, 5 сая төгрөгөөс дээш 7,106.7 мянган төгрөгийн 1 зарлагын гүйлгээ, 32,885,3 мянган төгрөгийн 3 орлогын гүйлгээг байршуулаагүй байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хэрэгжилтэд тусгайлсан аудит хийгдээгүй болно.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Дундговь аймгийн Биеийн тамир, спортын газрын 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хийгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 78,605.6 мянган төгрөгийн алдаа зөрчилд давтан гаргахгүй байх 1 зөвлөмж, 74,605.6 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|-----------------|------------------------|-----------------|----------|-----------------|--------------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Албан шаардлага | 7 | 74,605.6 | 7 | 74,605.6 | 100.0 |
| Зөвлөмж | 1 | 4,000.0 | 1 | 4,000.0 | 100.0 |
| Нийт дүн | 8 | 78,605.6 | 8 | 78,605.6 | 100.0 |

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар уралдаан тэмцээн зохион байгуулах зардал, үндсэн хөрөнгө, бараа материалын дотоод хөдөлгөөн, түүнд тавих хяналтад горим сорил хэрэгжүүлэх шаардлагатай.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 10,500.0 мянган төгрөгийн алдаа¹ илрүүлснийг аудитын явцад залрууллаа. Үүнд: Биетээр хүлээн аваагүй 10,500.0 мянган төгрөгийн 875 ширхэг бараа материалыг бүртгэлд тусгаж бараа материалаар бүртгэсэн байсныг залрууллаа.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1. "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: үнэн зөв байх, мөн хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй, бодитой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Аудитын тайланд залруулсан.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Аудитаар нийт 6,638.8 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 6,638.8 мянган төгрөгийн 4 заалт бүхий зөвлөмж өгсөн.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Анхан шатны баримтын иж бүрдэл хангалтгүй 6,600.0 мянган төгрөгийн ажил гүйлгээг бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 7 дахь заалт "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн хөрөнгөөр худалдан авч буй ажил үйлчилгээний төлбөр тооцоог хийхдээ хууль тогтоомжид заасан анхан шатны баримтын бүрдлийг хангаж, цаашид зөрчлийг дахин давтан гаргахгүй ажиллах;

2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дансанд хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэгдэл өртөггүй 194,198.4 мянган төгрөгийн 49 нэр төрлийн хөрөнгийн дахин үнэлгээг хийх, актлах талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2-т "Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтээж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох", "Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 6.2- т "Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг дараах тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрээр данснаас хасна", 6.2.1-д "Элэгдлийн нийт хэмжээ, ашиглалтын хугацаагаараа балансын үнээ бүрэн нөхсөн бөгөөд цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон", "үнэлгээ ба хуваарилалт", "иж бүрэн байх", "үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгийг журамд заасны дагуу үнэлгээг тогтоох, актлах талаар арга хэмжээ авч ажиллах;

3. Цалингийн тооцоололтой холбоотой асуудал

Илрүүлэлт: 11 дүгээр сарын цалингийн хүснэгтэд шууд бус орлогоос хувь хүний орлогын татварыг суутган авахдаа нийгмийн даатгал хассан дүнгээс тооцоолсон нь алдаатай байна. Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 1 дэх заалт "Энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан шууд бус орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо эдгээр орлогын нийт дүнгээр тооцно" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна

Өгсөн зөвлөмж: Хувь хүний орлогын албан татварын тооцооллыг хуульд заасны дагуу үнэн зөв тооцоолж байх.

4. Шилэн дансны мэдээлэл байршуулахтай холбоотой асуудал

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Илрүүлэлт: Шилэн дансны цахим сайтад 9 мэдээлэл хугацаа хоцроосон, 5 сая төгрөгөөс дээш 7,106,683.92 төгрөгийн 1 зарлагын гүйлгээ, 32,885,300.0 төгрөгийн 3 орлогын гүйлгээг мэдээлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хууль, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга нийтлэг стандарт тогтоосон журмыг уншиж судлан хэрэгжилтэд хяналт тавих, мэдээлэл байршуулах ажил хариуцсан ажилтны ажлын хариуцлагыг сайжруулах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Дундговь аймаг дахь төрийн аудитын газарт 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------|-----------------|-----------------------------------|-----|--------------------------|-----------------|------------|-----------------|--------------|-----|---------|-----|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Залруулсан | | Залруулаагүй | | Тоо | Дүн |
| | | | | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | | |
| Биетээр хүлээн аваагүй 10,500.0 мянган төгрөгийн 875 ширхэг бараа материалыг бүртгэлд тусгаж бараа материалаар бүртгэсэн | 1 | 10,500.0 | | | 1 | 10,500.0 | 1 | 10,500.0 | | | | |
| Дүн | 1 | 10,500.0 | | | 1 | 10,500.0 | 1 | 10,500.0 | | | | |

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------|-------------|---------------|-----|-----------------|-----|----------|-------------|--------------------------------------|---------------------|-------------------------------------------------|-----|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| 11 дүгээр сарын цалингийн хүснэгтэд шууд бус орлогоос хувь хүний орлогын татварыг суутган авахдаа нийгмийн даатгал хассан дүнгээс тооцоолсон нь алдаатай байна. | 1 | 38.8 | | | | | 1 | 38.8 | | | | |
| Дүн | 1 | 38.8 | | | | | 1 | 38.8 | | | | |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

| Зөрчлийн товч утга | /мянган төгрөгөөр/ | | | | | | | |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------|----------------|---------------|-----|-----------------|----------|----------|----------------|
| | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
| | Тоо | Дүн | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансны цахим сайтад 9 мэдээлэл хугацаа хоцроож, 5 сая төгрөгөөс дээш 7,106.7 мянган төгрөгийн 1 зарлагын гүйлгээ, 32,885,3 мянган төгрөгийн 3 орлогын гүйлгээг байршуулаагүй байна. | 1 | - | | | | | 1 | - |
| Дүн | 1 | - | | | | - | 1 | - |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Анхан шатны баримтын иж бүрдэл хангалтгүй 6,600.0 мянган төгрөгийн ажил гүйлгээг бүртгэсэн байна. | 1 | 6,600.0 | | | | | 1 | 6,600.0 |
| Үндсэн хөрөнгийн дансанд хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэгдэл өртөггүй 194,198.4 мянган төгрөгийн 49 нэр төрлийн хөрөнгийн дахин үнэлгээг хийх, актлах талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна. | 1 | - | | | | | 1 | - |
| Дүн | 2 | 6,600.0 | | | | | 2 | 6,600.0 |
| Нийт дүн | 3 | 6,600.0 | | | | | 3 | 6,600.0 |